



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/60

Шивээговь сум

Тэмцээнд оролцоход дэмжлэг
 үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын Соёлын төвийн дэргэдэх “Шивээн ганхаа-3, 4” хамтлаг нь Бүгд найрамдах Солонгос Улсын Соёл урлаг, Боловсрол Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Баянзүрх дүүргийн Соёлын ордон, “Шүрэн ундарга” төрийн бус байгууллагаас хамтран зохион байгуулж буй “SEOUL DANCE INTERNATIONAL” Олон Улсын бүжгийн тэмцээнд хамтлаг, гоцлол бүжгийн 6 төрлөөр оролцоход 700,000 (долоон зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй .

2.Тэмцээнд оролцох оролцооны 700,000 (долоон зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ), Соёлын төвийн дарга (Э.Төрмандах) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ

